



ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2014 оны 08 сарын 29 өдөр

Дугаар А/490

Эрдэнэт

Хөрөнгө шилжүүлэх тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2/г/, 29.2, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.2.1, 78.2.5, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тэргүүлэгчдийн 2017 оны 49 дүгээр тогтоолоор баталсан “Орон нутгийн өмчит хуулийн этгээд үндсэн хөрөнгө олж авах, бүртгэх, худалдах, шилжүүлэх, актлах журам”-ын 5.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сургуулиудын бүтэц зохион байгуулалтад өөрчлөлт орж байгаа тул 5 дугаар сургуулийн эд хөрөнгөнөөс 879,110,842.42 төгрөгийн өртөгтэй, 250,998,191.57 төгрөгийн хуримтлагдсан элэгдэлтэй, 628,112,650.85 төгрөгийн үлдэх өртөгтэй 6 нэр төрлийн эд хөрөнгийг 16 дугаар сургуульд хавсралтын ёсоор шилжүүлэхийг Орон нутгийн өмчийн газар /н.Оюунгэрэл/-т зөвшөөрсүгэй.

2. Шилжүүлэх хөрөнгийг актаар хүлээлгэн өгөхийг Орон нутгийн өмчийн газарт, санхүүгийн тайлан, үндсэн хөрөнгийн бүртгэлд зохих журмын дагуу өөрчлөлт оруулахыг холбогдох байгууллагын дарга, нягтлан бодогч нарт даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ



А.ТҮВШИНЖАРГАЛ



Аймгийн Засаг даргын 2017 оны
8 дугаар сарын 29-ны өдрийн
4/19 дугаар захирамжийн хавсралт

ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

Д/д	Хөрөнгийн нэр	Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл	Үлдэх өртөг
1	Барилга байгууламж	704,163,707.00	160,283,828.36	543,879,878.64
2	Нийтийн эзэмшил	5,140,800.00	4,450,800.00	690,000.00
3	Тоног төхөөрөмж	94,838,473.90	40,318,812.48	54,519,661.42
4	Тавилга эд хогшил	46,951,207.70	45,944,750.73	1,006,456.97
5	Тусгай зориулалтын материал	13,006,992.50	0	13,006,992.50
6	Ном сурах бичиг	15,009,661.32	0	15,009,661.32
Нийт дүн		879,110,842.42	250,998,191.57	628,112,650.85